

## “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар”-ыг ашиглах тайлбар

2020.10.20

### **Гарчиг**

1. Толь бичгийн танилцуулга
  - 1-1. Өмнөх үг
  - 1-2. Толь бичгийн гол онцлогууд
  - 1-3. Веб толины ажиллах орчин
  - 1-4. Веб толийг ашиглах нөхцөл
  - Усгийн фонтыг хялбар суулгах арга
2. Толь бичиг дэх үгийн тайлбар зүүлтийн бүтэц
3. Толийг ашиглах арга
  - 3-1. Толийг идэвхжүүлэх
  - 3-2. Дэлгэцийн бүтэц
    - 3-2-1. Хайлтын дэлгэц
    - 3-2-2. Товчлуурууд
    - 3-2-3. Хайлтын үр дүнг харуулах дэлгэц
    - 3-2-4. Толь бичгийн эхийг зургаар харуулах
    - 3-2-5. Дуудлагын сонсох
    - 3-2-6. Кирилл үсгийн бичилт
    - 3-2-7. Кирилл толь бичигтэй холбох линк
  - 3-3. Хайлт хийх аргууд
    - 3-3-1. Хайлтын хамрах хүрээ
      - 3-3-1-1. “Монгол бичиг” (Монгол үсгээр хайх)
      - 3-3-1-2. “Латин гилиг” (Латин галигаар хайх)
      - 3-3-1-3. “Бүгдийг хайх” (Бүх үсэг тэмдэгтээс хайх)
      - “Бүгдийг хайх” горимын давуу тал
    - 3-3-2. Хайлтын аргын төрлүүд
    - 3-3-3. Хайлтын нэмэлт сонголтууд
      - 3-3-3-1. Тодорхой бус хайлт
        - Тодорхой бус хайлтын давуу тал
      - 3-3-3-2. Усгийн том жижгийг үл хэрэгсэх
      - 3-3-3-3. Дэд толгой үгийн хасах (Зөвхөн гол толгой үгийг хайх)
    - 3-4. Хайлтын үр дүнг харуулах
      - 3-4-1. Хайлтын үр дүнг харуулах дэлгэц
      - 3-4-2. Хайлтаар олдсон илэрцийн тоог харуулах
      - 3-4-3. Хайлтын үр дүн нэг дэлгэцэнд багтаж харагдахгүй тохиолдолд
      - 3-4-4. Нэн дэлгэцэнд гарах мөрийн тоо
      - 3-4-5. Толь бичгийн эх хувийг харуулах
      - 3-4-6. Хайлтын дүнгээ хувилах болон хэвлэх
  - Нэмэлт тайлбар
    - Нэмэлт 1. “Монгол-Хятад толь бичиг” номын тухай
    - Нэмэлт 2. Компьютерын гарны товчнууд ба монгол үсэг, латин галигийн хамаарлын жишээнүүд
    - Нэмэлт 3. Монгол бичгээр хайлт хийхэд анхаарах зүйлс

## **1. Толь бичгийн танилцуулга**

### **1-1. Өмнөх үг**

Энэхүү “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар” нь Өвөр Монголын их сургуулийн (ӨМИС) Монгол судлалын хүрээлэнгийн Монгол хэл судлалын тэнхимээс эмхэтгэн гаргасан “Монгол-Хятад толь бичиг: нэмж засварласан хэвлэл”(ӨМИС-ийн хэвлэлийн газар, 1999) толь бичгийн материалыг цахим орчинд оруулан интернэтээр дамжуулан хайлт хийх, ашиглах боломжтой болгосон бүтээл болно.

“Монгол-Хятад толь бичиг: нэмж засварласан хэвлэл” толь бичгийг цахим хэрэглээнд оруулах төсөл нь Японы Тоохоку их сургуулийн зүүн хойд ази судлалын төв болон Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын хүрээлэн хамтарсан судалгааны ажлын үр дүн бөгөөд, мөн “АЛМАС” ХК (ALMAS Inc.)-ны техник технологийн хамтын ажиллагааны тусlamj дэмжлэгээр бодит ажил болсон билээ.

### **1-2. Толь бичгийн гол онцлогууд**

- “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар” нь монгол бичгээр дан үгийн хайлтыг хийж болдог бөгөөд хайх үгээ оруулах цонхонд (хайлтын цонх) компьютерын гараас өгөгдлөө оруулахад автоматаар монгол бичигт солигддог. Монгол бичгийн фонт нь Unicode-ын стандартад үндэслэн хийгдсэн болно.
- Уг толь нь толгой үгээр (монгол бичгээр бичигдсэн) хайлт хийж болдоос гадна, латин үсгээр галигласан монгол бичиг, хятад орчуулга (хялбаршуулсан ханз үсэгтэй) болон монгол хэл дээрх жишээ өгүүлбэр зэрэг “бүх өгөгдөл”-ийг нэг дор хайх боломжтой юм.
- Монгол бичигт ижил бичлэгтэй боловч өөр үсгүүд болох “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд байдаг. Ийм “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг бүхий үгийг хайхад төвөггүй болгохын тулд, монгол бичгийн бичлэгт үндэслэн хайх “Тодорхой бус хайлт” гэсэн хайлтыг оруулж өгсөн.
- “Монгол-Хятад толь бичиг” номны эх хуудсыг дэлгэцэнд зурган хэлбэрээр үзэх боломжтой.
- Толгой үгний дуудлагыг сонсох боломжтой.
- Толгой үгний кирилл үсгээрх бичилтийг хавсарган оруулсан учир, кирилл үсгийн бичилтээс нь кирилл толь бичиг рүү шилжин орж тайлбар сэлтийг үзэж ашиглах боломжтой.

### **1-3. Веб толинын ажиллах орчин**

Тус “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар” нь веб броузерийн тусlamjтай ажилладаг.

Санал болгох орчны хувьд, үйлдлийн систем нь Windows7-гоос хойших, веб броузерийн хувьд Firefox, түүнчлэн IE9-өөс хойших броузер байна. Өөр үйлдлийн систем болон броузерээр ажиллах боловч, монгол бичгийн үсгүүд хоорондоо зөв холбогдохгүй тасрах, хайлтын үр дүнгийн гол хэсгүүд улаан өнгөтэй болохгүй байх зэрэг тохиолдол гарч болзошгүй.

## 1-4. Веб толийг ашиглах нөхцөл

Монгол бичиг болон монгол хэлний латин галигийг дэлгэцэнд үнэн зөв харуулахын тулд компьютертээ дараах үсгийн фонтуудыг суулгасан байх шаардлагатай:

Mongolian Universal White (Монгол үсгийн тэмдэгтийг харуулах, оруулах)

Moukan Goth12 (Латин үсгийн галигийг харуулах, оруулах)


Үсгийн фонтыг дараах сайт дээр оруулсан. Доорх сайтаас татан авч өөрийн компьютертээ суулгаарай.

<http://hkuri.cneas.tohoku.ac.jp/p01/font>


Суулгах үедээ, фонт файлыг өөрийн компьютертээ хадгалж (татан авч), түүнийгээ “Фонт” фолдер руу хуулна. “Фонт” фолдер нь С дискний “Windows” фолдер дотор байдаг.

### ■ Үсгийн фонтыг хялбар суулгах арга


(1) Фонтын нэрэн дээр клик дарна.



(2) Нээгдсэн цонхны “Программыг нээх” гэсэн хэсгийг сонгоод “OK” дарна.



(3) Дэлгээцийн зүүн дээд хэсэгт байгаа “Install” гэсэн товчийг дарна.




Дээрх үйлдлийг хийх үед “Энэ программыг ажиллуулах уу” гэсэн утга бүхий баталгаажуулах дэлгэц гарсан тохиолдолд “Ажиллуулах” гэсэн товчийг дарж үргэлжлүүлээрэй.

## 2. Толь бичиг дэх толгой үгийн тайлбар зүүлтийн бүтэц

Толгой үгийн тайлбарын хэсэгт “Үндсэн толгой үг” ба “Дэд толгой үг” гэсэн 2 хэсэг байдаг. “Дэд толгой үг” гэдэг нь үндсэн толгой үгийг агуулсан холбоо ба хоршоо үг юм.

**Толин дээрх жишээ:**




“Үндсэн толгой үг” нь дараах 5 төрлийн тайлбар зүүлтийг агуулна:

- ① Монгол хэл дээрх толгой үг  
(Монгол бичгээр бичигдсэн)
- ② Латин үсгийн галиг
- ③ Дуудлага (Олон улсын авианы тэмдэглэгээгээр)
- ④ Үгсийн аймаг
- ⑤ Хятад хэлний орчуулга,  
Мөн түүнчлэн жишээ өгүүлбэр болон түүний орчуулга



“Дэд толгой үг” нь дараах 2 төрлийн тайлбар зүүлтийг агуулна:



### 3. Толийг ашиглах арга


#### 3-1. Толийг идэвхжүүлэх

Веб броузераасаа доорх хаягийг идэвхжүүлнэ:

<http://hkuri.cneas.tohoku.ac.jp/p01/>

Тэгмэгц дараах дэлгэц гарч ирнэ.


## “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар” сайтын нүүр хуудас



### 3-2. Дэлгэцийн бүтэц

#### 3-2-1. Хайлтын дэлгэц

Хайлтын дэлгэцэнд дараах 7 цонх байна.



##### ① Хайлтын цонх (Хайх үгээ оруулах цонх)

Хайх гэж буй үгээ оруулна. Компьютерын гараас шууд бичиж оруулсан ч, хуулж авсан үгээ зөөж оруулсан ч болно.

##### ② Хайлтын хамрах хүрээг сонгох цонх

Аль төрлийн тэмдэгтээр хайлт хийхийг (монгол бичиг, латин үсгийн галиг болон бусад) сонгоно.

##### ③ Хайлтын аргачлал сонгох цонх

##### ④ Хайлтын нэмэлт сонголтын цонх

##### ⑤ Дэлгэцэнд үзүүлэх мөрийн тоог сонгох цонх (сонголтын цэснээс тоогоо сонгоно)

##### ⑥ Толины төрлийг сонгоно (сонголтын цэснээс тохирох толины төрлийг сонгоно)

Хэд хэдэн толь бичиг сонголтын цэсэнд байгаа тохиолдолд тэдгээрийн дундаас толины төрлийг сонгоно. (Тус “Монгол-Хятад толь” хэсэгт нэг л толийн өгөгдөл орсон байна.)

##### ⑦ Тусlamж цонх (сонголтын цэснээс сонгоно)

Гарны товчлуур дээрх монгол бичгийн үсгийн байршлыг харж болно.

#### 3-2-2. Товчлуурууд

## Mongolian Dic

推荐 : Windows 7 以後 Firefox, IE9 以降

Help ▾

The screenshot shows the Mongolian Dic search interface. The search bar contains the query "Хайлтыг эхлүүлэх товчлуур". Below the search bar are several buttons: a magnifying glass icon (①), a clipboard icon (②), and a refresh/circular arrow icon (③). To the right of the search bar are checkboxes for search modes: "蒙文词条" (selected), "转写字母", "全文", "前段一致" (selected), "完全一致", "后段一致", "部分一致", "模糊查询", "不分大小写", and "不包括副条". On the far right, there are dropdown menus for "蒙汉词典" (set to "蒙汉词典") and "30行".

- ① Хайлтыг эхлүүлэх товчлуур

Хайлтыг эхлүүлнэ. (Мөн гарны “Enter” товчийг дарж орлуулж болно)

- ② Хайлтын цонхон дахь үсэг тэмдэгтийг арилгах товчлуур

Хайлтын цонхонд байгаа үсэг тэмдэгтийг бүгдийг нь арилгана. (Мөн гарны “Esc” товчийг дарж орлуулж болно)

- ③ Бүх толийг сонгох товчлуур

Цэсэнд хэд хэдэн толь бүртгэлтэй байгаа тохиолдолд тэдгээрийг бүгдийг нэгэн зэрэг сонгоно. Тус “Монгол-Хятад” толийн хувьд ганц л толь бүртгэгдсэн учир хэрэглэх шаардлагагүй юм.

### 3-2-3. Хайлтын үр дүнг харуулах дэлгэц

Дараах дэлгэцэнд хайлтын цонхон дээр 𩫚 (toli) гэсэн үгийг оруулж хайлт хийхэд гарах үр дүнг харуулав:

The screenshot shows the Mongolian/Mongol dictionary interface. The search bar contains the query "толи". Below the search bar are buttons: a magnifying glass icon (①), a clipboard icon (②), and a refresh/circular arrow icon (③). To the right of the search bar are checkboxes for search modes: "蒙文词条" (selected), "转写字母", "全文", "前段一致" (selected), "完全一致", "后段一致", "部分一致", "模糊查询", "不分大小写", and "不包括副条". On the far right, there are dropdown menus for "蒙汉词典" (set to "蒙汉词典") and "30行".

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文	页/段
𩫚(toli)	toli(n) /1	tɔel	(名) ①镜子 ②犁镜 ③(转) 镜, 般 鉴, 借鉴: 𩫚 𩫚 借鉴 ④(旧) 护 心镜 ⑤指甲根。	1072a
	toli /2	tɔel	(名) 字典, 词典: 𩫚 𩫚 解释词 典; 𩫚 𩫚 百科词典。	1072a
	toli Jüi		= 𩫚 𩫚 (本段: 1072a)	1072a
	toli üges		收进词典的词语。	1072a
	tolin-u ger		镜袋。	1072a

- ① Толгой үг (монгол бичгээр харуулсан)

- ② Толгой үгний латин үсгийн галиг

- ③ Толгой үгийн дуудлагын олон улсын авианы тэмдэглэгээ, мөн түүний дуудлагыг сонсох товчлуур, кирилл үсгийн бичилт.

Кирилл үсгийн бичилт нь кирилл үсгийн толь бичигтэй линкээр холбогдсон.

- ④ Хятад орчуулга (хялбаршуулсан ханз үсгээр), жишээ (монгол үсгээр) болон

жишээний хятад орчуулга (хялбаршуулсан ханз үсгээр)

- ⑤ Номын эх дээрх тухайн үгийн байрлал (хуудасны дугаар болон эгнээ). Номын эхийн зурагт файлтай линкээр холбогдсон байдаг.
- ⑥ Хайлтын илэрцийн тоо  
Хайлтаар олдсон үгнүүдийн тоог харуулна.
- ⑦ Хэд хэдэн дэлгэцийн хооронд шилжих (доорх зургаас үзнэ үү)  
Хайлтын үр дүн нэг дэлгэцэнд багтахгүй тохиолдолд дэлгэц хооронд шилжих товчлуур гарч ирдэг. Тоон тэмдэглэгээ нь дэлгэцийн дугаарыг заана.



The screenshot shows a table of search results for the word 'tolidayulchu'. The results are as follows:

толидайулчу	tolidayulchu	tøeldu:lax	(不及) = толидайулчу (中段:1072b)	1072c
толидайур	tolidayur	tøeldu:r	(名) 投光机。	1072c
толичин	tolicin	tøeltʃin	(名) 词典学家, 词书编纂者。	1072c


Below the table is a navigation bar with page numbers 1, 2, and 3, where page 1 is highlighted. A red circle with the number ⑦ is placed over the search results table.

Хайлт хийсэн үсэг тэмдэгт бүхий үг олдоогүй тохиолдолд “Not Found!” гэсэн бичиг гарна.




### 3-2-4. Толь бичгийн эхийг зургаар харуулах

Хайлтын үр дүнд тухайн үгийн эх ном дээрх байрлалыг заасан хуудасны дугаар гарч ирэх ба, тэрхүү дугаар нь номын эх зурагтай линкээр холбогдсон. Номын хуудасны зураг дээр дарвал хуудасны зураг томорч харагдана.



Эх номын зургийг дэлгэцийнхээ тохиромжтой байрлалд шилжүүлэх, мөн томруулах ба жижгэрүүлэн харах боломжтой.

Зургийн дээд хэсэгт курсороо тохируулаад 1 дараад хөдөлгөвөл зураг томрох ба, дахин нэг дараахад анхны хэмжээндээ буцаж орно.



### 3-2-5. Дуудлагыг сонсох

Үгийн дуудлагыг олон улсын тэмдэглэгээгээр илэрхийлсэн хэсгийн баруун талд чанга яригчийн дүрстэй (👉) тэмдэг байдаг ба түүнийг дарвал тухайн үгийн дуудлагыг төрөлх хэлээрээ яригчийн дуу хоолойгоор сонсож болно.

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
𠂇(၏)	toli(n) /1	tœl (tɔ:l) ТОЛЬ(ТОЛИН) -	(名) ①镜子 ②犁镜 ③〈转 鉴, 借鉴: 𠂇 𠂇 借鉴 ④ 心镜 ⑤指甲根。

### 3-2-6. Кирилл үсгийн бичилт

Дуудлагын тэмдэглэгээний доод талд тухайн үгний кирилл бичилтийг оруулсан.

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
𠂇(၏)	toli(n) /1	tœl (tɔ:l) ТОЛЬ(ТОЛИН) -	(名) ①镜子 ②犁镜 ③〈转 鉴, 借鉴: 𠂇 𠂇 借鉴 ④ 心镜 ⑤指甲根。

Кирилл үсгийн бичилт нь кирилл толь бичигтэй линкээр холбогдсон бөгөөд, кирилл бичилт дээр дарвал Я. Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь (1966)” ном руу шууд шилжин хайлт хийгдэнэ.

### 3-2-7. Кирилл толь бичигтэй холбогдох линк

Кирилл бичилтийн баруун талд байх ▼ суман дээр дарвал кирилл толь бичгийн жагсаалт сонголтын цэсээр гарч ирнэ.

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
толь(толь)	tol(n) /1	tœl (tœl)	(名) ①镜子 ②犁镜 ③〈转 толь(толин) 镜, 借鉴: толь 陈年 陈年 借鉴 ④ 心镜 ⑤指甲根。

Сумны тэмдэг (▼) дээр дараах дараах байдлаар кирилл толь бичгийн жагсаалт сонголтын цэсээр гарч ирнэ:

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
толь(толь)	tol(n) /1	tœl (tœl)	(名) ①镜子 ②犁镜 ③〈转 толь(толин) 镜, 借鉴: толь 陈年 陈年 借鉴 ④ 心镜 ⑤指甲根。
толь	tol /2	tœl (tœl)	词典: толь 陈年 陈年 百科词典。
толь ярийн	tolü üges		蒙古语 Харь уг
толь/толь	tolin-u ger		镜袋。

Гарч ирсэн толь бичгийн нэр дээр дараад тухайн толь бичгийн линк рүү шууд шилжин кирилл үсгээр үгийн хайлт хийгдэнэ.

### 3-3. Хайлт хийх аргууд

- Юуны өмнө монгол бичиг болон латин үсгийн галигт зориулсан үсгийн фонтуудыг татан авч суулгаарай.
- ⇒ ■ Усгийн фонтыг хялбар суулгах арга
- Манай сайтад хандаж “Монгол-Хятад толь” гэсэн дэлгэцийг гаргана.
- ⇒ 3-1. Толийг идэвхжүүлэх

#### 3-3-1. Хайлтын хамрах хүрээ

“Хайлтын хамрах хүрээ”-ний заалтад ①-③ гэсэн гурван төрөл байна:

Төрөл зүйл	Аль хэсгээс хайх	Үсгэн тэмдэгт
① Монгол бичиг	Толгой үгийн (монгол бичиг) хэсэг	Монгол бичиг
② Латин галиг	Латин галигтай хэсэг	Латин галиг
③ Бүгдийг хайх	Толгой үг (монгол бичгээр), латин галиг, үсгийн аймаг болон хятад орчуулга зэрэг хуудас дээрх бүх хэсэг	Монгол бичиг, латин галиг, хятад ханз үсэг

##### 3-3-1-1. “Монгол бичиг” (Монгол үсгээр хайх)

- (1) “Монгол бичиг” гэсэн товчийг сонгоно. (анхны тохиргоогоор нь үлдээнэ)
- (2) Үсгэн тэмдэгт оруулах гарын драйвер (IME) идэвхэжсэн байгаа бол, үсэг оруулах горимыг “Хагас өргөн латин үсэг ба цифр” болгоно. (Эсвэл үсэг оруулах хэлийг “English” болгоно.)
- (3) Хайлтын цонхонд курсороо тохируулсан эсэхээ шалгана.
- (4) Компьютерын гарнаас үсэг дараахад хайлтын цонхон дээр монгол бичгээр гарна.
- (5) Хайх үгээ үсэг тэмдэгтээр бичиж оруулсны дараа “Enter” товчийг дарна. (Эсвэл хайлтын цонхны баруун талд байх томруулдаг шилний зурагтай товчлуурыг дарж хайлт хийх арга ч байдаг.)
- (6) Хайлт явагдаж, хайлтын үр дүн дэлгэцэнд гарч ирнэ. Хайлтын цонхонд бичсэн үгтэй нийцэх хэсэг нь улаан өнгөөр гарч ирдэг. Хайлтад тохирох үг олдоогүй бол “Not Found!” гэсэн бичиг гардаг.

### **3-3-1-2. “Латин галиг” (Латин галигаар хайх)**

“Хайлтын хэлбэр” хэсэгт “Латин галиг” гэснийг сонгоно.



Компьютерын гарнаас үсэг бичихэд автоматаар латин үсгийн галиг гарч ирнэ.

■ Компьютерын гарны товчнууд ба монгол үсэг, латин галигийн хамаарал

Монгол бичиг	Латин галиг	Гарны товч
Эгшиг үсэг		
ӝ	a	a
ӟ	e	e
ӝ	i	i
ӝ	o	o
ӝ	u	u
ӟ	O	O (Том)
ӟ	U	U (Том) v
ӟ	E	E (Том)
Гийгүүлэгч үсэг		
н	n	n
়	ng	ng N
়	b	b
়	p	p
়	q	q h
়	k	k
়	G	G (Том) g
়	g	g
়	m	m
়	l	l
়	s	s
়	S	S (Том)
়	t	t
়	d	d

Монгол бичиг	Латин галиг	Гарны товч
ҹ	c	c
ӂ	j	j
ӝ	y	y
ӂ	r	r
ӝ	w	w
Гадаад үгийг бичих үсэг		
়	f	f
়	x	K (Том)
়	K	Q (Том)
়	C	C (Том)
়	c	x
়	z	z
়	H	H (Том)
়	R	R (Том)
়	L	L (Том)
়	Z	Z (Том)
MVS	(Доогуур зураас)	(Доогуур зураас)
NNBSP	- (Дундуур зураас)	- (Дундуур зураас)

Монгол үсгийн гарны товчны байрлалыг тус цахим толийн дэлгэцийн баруун дээд талд байгаа “Help” гэснийг дарж харах боломжтой. Гарнаас монгол үсгээр оруулах болон латин галигийг хэрхэн яаж оруулах талаар нарийвчилсан жишээг нэмэлт тайлбар хэсгээс үзээрэй.

⇒ Нэмэлт тайлбар 2. Гарны товчнууд ба монгол үсэг, латин галигийн хамаарлын жишээ

## ▪ Хайлтын цонхны түүхийг харах

Нэг удаа хайлт хийсэн үг цаашид хадгалагдан үлддэг бөгөөд хайлтын цонхны зүүн захад байгаа ▼ сумыг дарахад сонголтын цэс хэлбэрээр гарч ирдэг. (хайлтын түүх) Сонголтын цэсний хамгийн доор байх “CLEAR” гэснийг дарвал хайлтын түүх бүгд устдаг.

The screenshot shows a search interface for a Mongolian dictionary. The search bar at the top contains the query 'tabu(n)'. Below the search bar is a table with three columns: '转写字母' (Transliteration), '国际音标' (International Phonetic Alphabet), and '词类/中文译文' (Part of Speech / Chinese Translation). The first result is 'tabu(n)' with transliteration 'tab' and definition '(数) ①五 ②五个(只、件……) ③五次(回、下……) ④五岁。'. The second result is 'tabun amta' with definition '五味(蒙古语 甜, 蒙古语 或 蒙古语 酸, 蒙古语 苦, 蒙古语 或 蒙古语 辣, 蒙古语 或 蒙古语 咸)'. The third result is 'tabun egüride' with definition '〈旧〉五常(儒家所宣扬的道德教条, 指: 蒙古语 仁, 蒙古语 义, 蒙古语 礼, 蒙古语 智, 蒙古语 信)'. A red box highlights the search results table.

### 3-3-1-3. “Бүгдийг хайх” (Бүх үсэг тэмдэгтээс хайх)

“Бүгдийг хайх” нь толгой үг, латин галиг, хятад орчуулга, жишээ өгүүлбэр зэрэг бүх үсэг тэмдэгт дотроос хайлтыг явуулдаг.

(1) “Хайлтын хэлбэр” хэсгийг “бүгдийг хайх” болгоно.

The screenshot shows the Mongolian Dictionary search interface. The search bar contains the query 'tabu(n)'. The '全文' (Full Text) button is highlighted with a red circle. Other search options like '前段一致' (Partial Match), '完全一致' (Exact Match), '后段一致' (Partial Match), and '部分一致' (Partial Match) are also visible. The results table is partially visible below the search bar.

(2) Хайлтын цонхон дээр курсороо тохируулсан эсэхээ шалгана.

(3) Хайхыг хүссэн үсэг тэмдгийн төрөлд тохирох драйверыг (IME) сонгоно. Харин “Бүгдийг хайх” горимоор хайлт хийхэд шаардлагатай хятад үсэг (хялбаршуулсан ханз) болон монгол бичгийн үсгийг оруулах драйвер (IME) нь тус “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар”-д суулгагдаагүй учраас хэрэглэгч өөрөө тухайн тохиргоог хийх шаардлагатай.

(4) Гарны товчийг дарахад хайлтын цонхонд үсгэн тэмдэгт гарч ирнэ.

(5) Хайхыг хүссэн үгээ бичиж оруулаад “Enter” товчийг дарна.

(6) Хайлт явагдаж дуусахад хайлтын үр дүн дэлгэцэнд гарч ирнэ.

Хайлтын цонхонд бичсэн үгтэй нийцэх хэсэг нь улаан өнгөөр гарч ирдэг.

Хайлтад таарах үг байхгүй (хайлтад тохирох зүйл байхгүй) бол “Not Found!” (тохирох үг олдсонгүй) гэсэн бичиг гардаг.

## ■ “Бүгдийг хайх” горимын давуу тал

“Бүгдийг хайх” горим сонгосон үед хайлтын цонхонд хятад хэлээр (хялбаршуулсан ханз) үг оруулбал нэг төрлийн “Хятад-Монгол толь” болгон хэрэглэж болно. Хятад үгийг

(хялбаршуулсан ханз) оруулахдаа хэрэглэгч өөрийн компьютерын системээр бичиж оруулна. Мөн хятад бичгээс үгээ хуулж зөөгөөд тавьсан ч болдог.

- “Бүгдийг хайх” горимоор хятад хэлний “词典” гэсэн үгийг оруулж хайсан үр дүнг харуулав. (Дэлгэцийн нэг хэсэгт):



The screenshot shows a search interface for a Chinese-Mongolian dictionary. The search term '词典' is entered in the search bar. The results table has columns for 蒙文词条 (Mongolian Word), 转写字母 (Pinyin Transliteration), 国际音标 (International Phonetic Alphabet), and 词类/中文译文 (Part of Speech/Chinese Translation). The results include:

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
𠂇 𩫑 / 𩫑	üge-yin γarul		〈语〉词源: 𠂇 𩫑 / 𩫑 𩫑 词源词典。311b
𢃠 𩫑	nairayulχu	næ:ru:lăx	(及) ①调制, 配制, 调合, 调配: 𩫑 𩫑 配药 ②编, 编写, 编辑, 编纂: 𩫑 𩫑 编词典。335a
𢃠 𩫑	χabsurχu /1	xabsrăx	(及) ①帮, 助, 辅助, 帮助, 协助, 辅佐: 𩫑 𩫑 帮助别人 ②兼做, 兼办 ③附 ④合, 配合: 𩫑 𩫑 合掌; 𩫑 / 𩫑 / 𩫑 𩫑 𩫑 五体合璧词典。546c
𢃠 𩫑	γaliyyu toli		注音词典。742a
𢃠 𩫑	tailburi toli		解释词典。993b
𢃠 𩫑 𩫑	tongyorau toli bičig		倒序词典。1054c

“Бүгдийг хайх” горимоор хайлтын цонхонд монгол бичгээр үг оруулахад орчуулгын жишээ болон жишээ өгүүлбэр нь ч бас хайлтын үр дүн болон гарч ирнэ.

- “Бүгдийг хайх” горимоор монгол хэлний “𢃠 (toli)” гэсэн үгийг хайхад гарах үр дүн (дэлгэцийн нэг хэсэг):



The screenshot shows a search interface for a Chinese-Mongolian dictionary. The search term '𢃠' is entered in the search bar. The results table has columns for 蒙文词条 (Mongolian Word), 转写字母 (Pinyin Transliteration), 国际音标 (International Phonetic Alphabet), and 词类/中文译文 (Part of Speech/Chinese Translation). The results include:

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
𢃠 / 𩫑	anjisun-u toli		犁镜。16b
𢃠	arčimal	artʃmäl~aertʃmäl	(形)清淨的, 擦得明亮的, 纯淨的: 𢃠 𩫑 純淨的水晶镜。95b
𢃠 𩫑	oilγaxu toli		〈物〉反射镜。187a
𢃠 / 𩫑	on-u toli		年鉴。188c
𠂇 𩫑 / 𩫑	üge-yin γarul		〈语〉词源: 𠂇 𩫑 / 𩫑 𩫑 𩫑 词源词典。311b

### 3-3-2. Хайлтын аргын төрлүүд

“Хайлтын арга”-ыг зааж өгөх хэсэгт дараах 4 төрөл байна.



Хайлтын аргын төрлүүд	Үйлдэл
Эхний хэсэг нь таарах	Хайлтад оруулсан үсгүүдээр эхэлсэн үгийг хайна.
Бүх хэсэг нь таарах	Хайлтад оруулсан үсгүүдтэй бүрэн таарах үгийг хайна
Сүүлийн хэсэг нь таарах	Хайлтад оруулсан үсгүүдээр төгссөн үгийг хайна.
Хэсэгчлэн таарах	Хайлтад оруулсан үсгүүдийг агуулсан үгийг хайна.

Хайлтын хамрах хүрээ нь “Монгол бичиг” болон “Латин галиг” байгаа тохиолдолд здгээрийн хайлтын аргын дотроос аль аргыг ч сонгож болох боловч “Бүгдийг хайх” горимыг сонгосон тохиолдолд хайлтын арга нь автоматаар “Хэсэгчлэн таарах үг” болдог. (Өөр хайлтын аргыг сонгох боломжгүй болно.)

### 3-3-3. Хайлтын нэмэлт сонголтууд

Хайлтын нэмэлт сонголт нь дараах 3 төрөл байдаг:



Төрөл	Хайлтын хамрах хүрээ	Үйлдэл
Тодорхой бус хайлт	Монгол бичиг	Тодорхой бус хайлт явуулна
Үсгийн том жижгийг үл хэрэгсэх	Латин галиг	Гараас оруулах үсгүүдийн том жижиг эсэхийг үл ялгаран халт хийх. Тус сонголтыг зөвхөн латин галигаар хайлт хийхэд ашигладаг.
Дэд толгой үгийг хасах	Монгол бичиг болон латин галиг	Дэд толгой үгийг хайлтын хамрах хүрээнээс хасна.

#### 3-3-3-1. Тодорхой бус хайлт

Тодорхой бус хайлт (“模糊查询”) нь дараах маягийн хос үсгүүдийг нэгэн адилд үзэн хайлт явуулдаг.

- Эгшиг үсэг болох **o** ба **u** үсгүүдийг нэгэн адилд үзнэ. Аль үсгээр нь хайсан ч хоёр үсэг аль аль нь хайлтаар сонгогдон гарч ирнэ.
- Эгшиг үсэг болох **O** ба **U** үсгүүдийг нэгэн адилд үзнэ. Аль үсгээр нь хайсан ч хоёр үсэг аль аль нь хайлтаар сонгогдон гарч ирнэ.
- Үгийн эхэнд ороогүй **a** ба **e** эгшигүүдийг мөн нэгэн адилд тооцон хайдаг. Аль үсгээр хайсан ч хоёр үсэг аль аль нь хайлтаар сонгогдон гарч ирнэ.
- Гийгүүлэгч үсэг болох **t** болон **d** үсгүүдийг мөн нэгэн адилд тооцон хайна. Аль үсгээр нь хайсан ч хоёр үсэг аль аль нь хайлтаар сонгогдон гарч ирнэ.
- Гийгүүлэгч үсэг болох **k** ба **g** үсгүүдийг бас нэгэн адилд тооцон хайна. Аль үсгээр нь

хайсан ч хоёр үсэг аль аль нь хайлтаар сонгогдоно.

Тодорхой бус хайлтыг хэрэглэхдээ “Тодорхой бус хайлт (模糊查询)” гэсэн хэсгийг сонгож бөглөнө.



### ■ Тодорхой бус хайлтын давуу тал

Ер нь монгол хэлэнд “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд олонтой учраас, зөвхөн үгний бичлэгээр нь толь бичгээс хайхад төдийлөн амаргүй байдаг. Тухайлбал, **ᠲ** гэдэг бичлэгтэй үгийн хувьд, **t** ба **d**, мөн **o** болон **u** гэсэн хоёр төрлийн “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд орсон байдаг ба, үсгийн дуудлагын хувьд **toli**, **doli**, **tuli**, **duli** гэж дөрвөн янзаар галиглах боломжтой байдаг. Иймд эдгээрийн яг аль нь эсэхийг монгол бичгийн (**ᠲ**) бичилтээс олж тогтоох боломжгүй юм.

Монгол бичигт ийм маягийн “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг хэд хэд байдаг нь монгол хэл сурхад ихээхэн бэрхшээлийг учруулдаг билээ. Монгол бичгээр бичигдсэн ямар нэг үгийг толь бичгээс харах үед тухайн үгийн бичилтэнд “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг орсон байвал тэр үгний дуудлага ч хэд хэдэн янз байх боломжтой болдог. “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг нэг орсон байвал хоёр янзаар дуудах, хоёр орсон бол дөрвөн янзаар, гурав орсон бол найман янзаар дуудах боломж байдаг тул тэдгээр хувилбаруудыг тус бүрчлэн нэг нэгээр нь лавлаж үзэх хэрэгтэй болно. Ийм маягаар толь бичиг дотроос өөрийн хайсан үгээ олон олтлоо тухайн үгийнхээ дуудлагыг олж мэдэх боломжгүй тул монгол хэл эхлэн суралцагчид толь бичиг барьж монгол бичвэр унших нь нэлээд цаг зав үрсэн ажил болдог юм.

Нөгөө талаар, монгол хүмүүст бас өөр асуудал байдаг. Монгол бичиг хэрэглэж буй БНХАУ дахь монгол үндэстний дотор маш олон аялга байдаг ба тэдгээрийн хооронд ялгаа зөрүү ч нэлээд байдаг. Мөн түүнчлэн, нэг мөр болсон стандарт аялга дэлгэрээгүй тул монгол бичгийг өөр өөрсдийн аялга болон дуудлагаараа уншицаар иржээ. “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгийн тухайд ч гэсэн аялга хоорондын ялгаа зөрөө ихтэй учраас, **t** ба **d**, **o** ба **u**, **g** ба **k**, **O** ба **U** зэрэг үсгүүд нь өөр хоорондоо холилдох явдал ч цөөнгүй байдаг. Монгол бичигт дээрх үсгүүд нь ижил бичлэгээр бичигддэг нь харин ч “Аялга хоорондын зөрөөг арилгах” үүрэг гүйцэтгэж иржээ. Нөхцөл байдал ийм байхад, монголчууд өөрсдөд нь ч гэсэн толь бичиг ашиглах нь тийм ч амар ажил биш байдаг. Ердийн толинд “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүдийг стандарт аялганы дуудлаганд тулгуурлан ялгаж, дараалал ёсоор оруулсан байдаг тул стандарт аялга сураагүй зарим монголчуудын хувьд өөр өөрсдийн аялгаар толь бичгээс яаж ч хайгаад өөрийн хайсан үгээ олж чаддаггүй тохиолдол гардаг юм.

Ийм мэтээр “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг орсон үгийг хайхад гарч болзошгүй

бэрхшээлийг хөнгөвчлөх үүднээс, энэхүү “Монгол-Хятад толь бичиг: цахим хувилбар”-т цахим хэлбэртэй гэдэг давуу талыг ашиглан “Тодорхой бус хайлт” гэдэг хайлтын сонголтыг оруулж өгсөн юм.

“Тодорхой бус хайлт” гэсэн хэсгийг сонгоход, “Бичлэг ижил, дуудлага өөр” гийгүүлэгч болох *t* ба *d*, *g* ба *k*, эгшиг үсэг болох *o* (4-р эгшиг) болон *u* (5-р эгшиг), *O* (6-р эгшиг) болон *U* (7-р эгшиг), мөн түүнчлэн үгийн эхний бус үеийн *a* болон *e* зэрэг үсгүүдийг үл ялгаварлан хайлт явагдана. Цаашилбал, үгийн 1-р үеийн *oi*, *ui*, *Oi*, *Ui* хос эгшгүүд ч мөн адил хэлбэрээр бичигдэх тул хайлт дээрхийн адил үл ялгасан байдлаар явагдана.

Бодитой жишээн дээр авч үзвэл, хайлтын цонхонд *toli*, *doli*, *tuli*, *duli* үгнүүдийн алийг нь ч оруулсан гэсэн хайлтын дүн бүгд адил ~~蒙古语~~ гэсэн бичилттэй үг болох учир ~~蒙古语~~ гэсэн хэлбэрийн бичилт бүхий үгнүүд (*toli*, *doli*, *tuli*, *duli*) бүгд хайлтаар гарч ирэх болно. “Тодорхой бус хайлт” нь монгол бичгийн бичилтээр хайлт хийх арга юм гэж хэлж болох юм.

Өөр бас нэг жишээнээс харвал, ~~蒙古语~~ гэсэн үг нь толь бичигт *oimoso* (“оимс”) гэж орсон байх боловч “Тодорхой бус хайлт”-аар эгшиг үсэг *o* (4-р эгшиг) болон *u* үсгийг (5-р эгшиг) үл ялгах учир *oimoso*, *oimosu*, *oimusu*, *oimuso*, *uimuso*, *uimoso*, *uimusu* гэсэн бичилтүүдийн дотроос алийгаар бичсэн ч хайлтын цонхонд ~~蒙古语~~ гэсэн үг болж солигдох ба хайлтын үр дүнд ~~蒙古语~~ (*oimoso* “оимс”) гэсэн үг гарч ирнэ. Мөн түүнчлэн *OimOsO*, *OimOsU*, *OimUsU*, *OimUsO*, *UimUsU*, *UimUsO*, *UimOsO*, *UimOsU* гэсэн бичилтүүд нь бүгд монгол бичгийн ~~蒙古语~~ гэсэн хэлбэртэй болдог тул дээрх латин галигуудаас алийг нь оруулсан нэгэн ижил үр дүн гарна.

“Тодорхой бус хайлт” нь хайлтын цонхонд оруулсан монгол бичгийн үгтэй адил хэлбэрийн бичилт бүхий үгнүүдийг толь бичиг дотроос хайн олоод дэлгэцэнд харуулдаг. Мөн алдаатай бичилтээр (дуудлагаар) хайлт оруулсан ч тухайн бичилтийн дагуу хайлт хийгээд тэдгээр үгнүүдийн “үнэн зөв” уншлага болон дуудлагыг харуулдаг. Ийм учраас “Бичлэг ижил, дуудлага өөр” үсэг бүхий үгийг хайхдаа “Тодорхой бус хайлт”-ыг ашиглан хайхыг зөвлөж байна.

### 3-3-3-2. Үсгийн том жижгийг үл хэрэгсэх

Хайлтын сонголт хэсэг дээр “Үсгийн том жижгийг үл хэрэгсэх” гэснийг сонгоод латин галигаар хайлт хийвэл, латин үсгийн том ба жижиг үсгийг үл ялган хайлт хийнэ. Хайлтын хамрах хүрээ “Латин галиг” болон “Бүгдийг хайх” байх үед ийм хайлт хүчинтэй болдог.




Бүр тодорхой хэлбэл, *o* ба *O*, *u* ба *U*, *g* ба *G* гэдэг үсгүүд ч гэсэн компьютерын

гарны том болон жижиг үсэг дээр хуваагдсан байдаг тул, эдгээр дотроос аль үсгээр хайлт хийсэн ч аль аль нь сонгогдон гарч ирнэ гэсэн үг юм.

### 3-3-3-3. Дэд толгой үгийн хасах (Зөвхөн гол толгой үгийг хайх)

Хайлтын сонголт хэсэг дээр “Дэд толгой үгийн хасах” гэснийг сонговол “Дэд толгой үг” (нийлмэл болон холбоо үгс)-ийг хайлтын хамрах хүрээнээс хасаж, зөвхөн “Үндсэн толгой үг”-ийг хайна.



“Дэд толгой үгийн хасах” гэдэг сонголтыг хийж “ᡨᠣᠯᡳ (toli)” гэсэн үгийг хайвал үгийн эхний хэсэгт “ᡨᠣᠯᡳ (toli)” гэдэг бичлэг орсон үндсэн толгой үгнүүд дэлгэцэнд гарч ирнэ.

The screenshot shows the search results for the query “толи”. The results table has columns: 'Mongolian Word', 'Pinyin', 'Pinyin (Input)', 'International Phonetic Alphabet', and 'Definition/Meaning'. The first four entries are:

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文	
ᡨᠣᠯᡳ(ᡩ)	toli(n) /1	tɔ̆l	(名) ①镜子 ②犁镜 ③〈转〉鉴, 殷鉴, 借鉴: ᡨᠣᠯᡳ 借鉴 ④〈旧〉护心镜 ⑤指甲根。	1072a
ᡨᠣᠯᡳ	toli /2	tɔ̆l	(名) 字典, 词典: ᡨᠣᠯᡳᡩ ᡨᠣᠯᡳ 解释词典; ᡨᠣᠯᡳᡩ ᡨᠣᠯᡳ 百科词典。	1072a
ᡨᠣᠯᡳᡩ	toliiχu	tɔ̆lɪχ	(不及) 变得光滑, 变得平滑, 变得平展: ᡨᠣᠯᡳᡩ ᡨᠣᠯᡳᡩ 衣服熨得平平的。	1072a
ᡨᠣᠯᡳᡩᡩ	toliiliγaxu	tɔ̆lɪlɪgɔ̆x	(及) 熨平, 平整: ᡨᠣᠯᡳᡩᡩ ᡨᠣᠯᡳᡩᡩ 熨平衣服。	1072a

### 3-4. Хайлтын үр дүнг харуулах

#### 3-4-1. Хайлтын үр дүнг харуулах дэлгэц

Хайлтын үр дүнг харуулах дэлгэц нь дараах таван баганаас (①-⑤) бүрддэг:

The screenshot shows the search results for the query “толи”. The results table has columns: 'Mongolian Word', 'Pinyin', 'Pinyin (Input)', 'International Phonetic Alphabet', and 'Definition/Meaning'. Red numbers ① through ⑤ are placed over the first four entries to indicate they are part of the numbered list from the previous section. The definitions for these entries include '镜子' (mirror), '犁镜' (plow mirror), '鉴, 殷鉴, 借鉴' (mirror, mirror of justice, loan mirror), '护心镜' (heart guard mirror), and '指甲根' (nail root).

Баганын төрлүүд	Үйлдэл
① Монгол бичиг	Толгой уг (монгол бичгээр): Хайлтаар оруулсан угтэй нийцэх хэсэг нь улаан өнгөөр гарч ирнэ.
② Латин галиг	Толгой уг нь латин галигаар гарч ирнэ. Толь бичгийн уг эх дээр латин галиг нь зөвхөн үндсэн толгой уг дээр бичигдсэн байгаа боловч энэхүү цахим толинд дэд толгой угэнд ч латин галиг бичигдсэн байгаа.
③ Олон улсын авианы тэмдэглэгээ	Толгой угэнд олон улсын авиан дуудлагын тэмдэгтээр дуудлагыг тавьсан. Гэхдээ зөвхөн гол толгой угэн дээр тавьж өгсөн
④ Үгсийн аймаг/ Хятад орчуулга	Үгсийн аймаг, хятад орчуулга (хялбаршуулсан ханз үсгээр), жишээнүүд (монгол бичгээр), мөн түүний хятад орчуулга (хялбаршуулсан ханз үсгээр)
⑤ Хуудас/ Эгнээ (Номын эхнээс дэлгэцд харуулах хэсэг)	Толь бичгийн эх хувийн хуудаснуудыг дугаараар заасан ба түүний ард байгаа а, б, с гэсэн үсэгнүүд нь тухайн хуудсан дахь дээд, дунд, доод гэсэн мөрний байрлалыг заана. Дугаарын дараход уг эхийн тухайн хуудасны дүрс гарч ирнэ.

### 3-4-2. Хайлтаар олдсон илэрцийн тоог харуулах

Хогийн савны дүрстэй айконы баруун талд хайлтаар олдсон тоо нь “Илэрцийн тоо: .....” гэж гарч ирнэ

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
镜(儿)	toli(n) /1	tœl	(名) ①镜子 ②犁镜 ③〈转〉鉴, 殷鉴, 借鉴: 镜 1072a 鑒 旧 ④〈旧〉护心镜 ⑤指甲根。
字典	toli /2	tœl	(名) 字典, 词典: 字典 旧 解释词典: 百科词典 1072a

### 3-4-3. Хайлтын үр дүн нэг удаагийн дэлгэцэнд багтаж харагдахааргүй тохиолдол

Хайлтын үр дүнг харуулах дэлгэцэнд энгийн үед нэг удаад 30 мөр (30 уг) харагдана. Хайлтын үр дүн 30 мөрнөөс (30 уг) давсан тохиолдолд, дэлгэцийн доод мөрөн дээр дэлгэцийн дугаарыг харуулсан тоо гарч ирдэг. Тэдгээр тоо юм уу эсвэл < болон > гэсэн тэмдэгнүүдийг дарж өөр дэлгэцүүдийг үзэх боломжтой.

### 3-4-4. Нэг дэлгэцэнд гарах мөрийн тоо

Нэг удаад дэлгэцэнд гарах мөрийн тоо нь энгийн үед 30 мөр (30 уг) байдаг боловч, үүнийг

10 мөрөөс 50 мөр хүртэл 10 мөрний нарийвчлалаар өөрчилж болдог.

Дэлгэцийн баруун талд байрлах “30 мөр” гэсэн хэсгийг дараад сонголтын цэснээс мөрийн тоогоо хүссэн хэмжээгээрээ сонгох боломжтой.



#### 3-4-5. Толь бичгийн эх хувийг харуулах

Эх толин дахь хуудсыг заасан дугаарыг дараход тухайн хуудасны дурс дэлгэцэнд томоор харагдана. Зургийнхаа дэлгэц дээрх байрлалыг хөдөлгөх, хэмжээг нь өөрчилж харах боломжтой.

Хуудасны зураг дээр дээр курсороо тааруулаад дарсан байдлаар хөдөлгөхөд тухайн хуудасны зургийн нэг хэсэг нь томорч харагдана.

#### 3-4-6. Хайлтын дүнгээ хувилах болон хэвлэх

Хайлтын үр дүнгээ хувилан өөр аплекейши дээр тавьж ашиглах боломжтой. Хэрэгцээтэй хэсгээ сонгоод, хувилан авахад таны компьютерын клипбоорд хэсэгт хадгалагдана.

Мөн хайлтын үр дүнгээ хэвлэх тохиолдолд броузерийнхаа хэвлэх функцийн ашиглаарай.


## Нэмэлт тайлбар

Нэмэлт 1. “Монгол-Хятад толь бичиг” номын тухай

Нэмэлт 2. Компьютерын гарны товчнууд ба монгол үсэг, латин галигийн хамаарлын жишээнүүд

Нэмэлт 3. Монгол бичгээр хайлт хийхдээ анхаарах зүйлс

### Нэмэлт 1. “Монгол-Хятад толь бичиг” номын тухай



1-1. Номын ерөнхий мэдээлэл

Өвөр Монголын их сургуулийн Монгол судлалын хүрээлэнгийн Монгол хэл судлалын тэнхимээс эмхэтгэн гаргасан “Монгол-Хятад толь бичиг: нэмж засварласан хэвлэл”(ӨМИС-ийн хэвлэлийн газар, 1999). А5 хэмжээтэй, Өмнөх үг ба таних тэмдэг 1-30-р хуудас. Гол агуулга 1-1414-р хуудас, Хавсралт 1415-1519-р хуудас.

Оруулсан үгс: Үндсэн толгой үг 26,445, дэд толгой үг (нийлмэл болон холбоо үгс) 27,296, нийт 53,741 орчим үгс.

Хавсралтын агуулга:

Монгол хэлний хэл зүйн тойм	1417-1511-р хуудас
Цэг таслалын хүснэгт	1512-р х.
Монгол бичгийн үндсэн бичлгийн хүснэгт	1513-1514-р х.
Үйгаржин монгол үсгийн цагаан толгой	1515-р х.
Дөрвөлжин үсгийн цагаан толгой	1516-1517-р хуудас
Тод үсгийн цагаан толгой	1518-1519-р хуудас

“Монгол-Хятад толь бичиг: нэмж засварласан хэвлэл”(ӨМИС-ийн хэвлэлийн газар, 1999) ” нь, БНХАУ-д амьдардаг Өвөр Монгол тэргүүтэй монгол үндэстнүүд хэрэглэхэд

зориулсан монгол хэлний толь бичиг юм. (цаашид “Монгол-Хятад толь” гэх). “Монгол-Хятад толь” нь анх 1960-аад оноос эмхэтгэгдэн бүтээгдэж эхэлсэн цагаасаа хойш, “Соёлын хувьсгал” зэрэг хүнд бэрх цаг үеийг дамжсаар 1976 онд анхны хэвлэл нь гарч байсан юм. Толины доторх үгийн тоо нь 50 мянга орчим үг буюу дэлхийн хэмжээнд ч хамгийн томд тооцогдох монгол хэлний толь бичиг бөгөөд, зөвхөн баялаг үгийн сантай гэдгээрээ төдийгүй, итгэж найдаж болохуйц агуулгатай гэдэг талаасаа ч БНХАУ дахь монгол хэлний бичгийн хэлний үндэс суурь хэмээх байр суурь нь улам бүр баталгаажсаар ирсэн билээ.

1999 онд гарсан “Нэмж засварласан хэвлэл” нь анхны хэвлэлтээс олсон толь бичгийг хэрэглэх дадлага туршлагадаа тулгуурлан зохих засвар, нэмэлтүүд зэргийг оруулсан бөгөөд, доторх агуулгын хувьд ч улам бүр бүрэн дүүрэн болсны дээр, шинээр толгой үгний дуудлагыг нэмж хийсэн нь гол онцлог болсон билээ.

Монгол бичиг бол хэдийгээр авианы бичиг үсэг боловч, бичгийн хэл болон ярианы хэлний хоорондох дуудлагын зөрүү ялгаа ихтэй байдгаас гадна, монгол хэлэнд олон тооны нутгийн аялга байдаг учир бичигдсэн үгнүүд нь аялга бүрийн онцлогоор уншигддаг онцлогтой. БНХАУ-д амьдарч буй монголчуудын доторх “хэлний стандарт аялга”-тай холбоотой маргаан хэлэлцүүлгүүд 1970-аад оноос эхлэн идэвхтэй өرنөж, Шилийн гол аймгийн Шулуун Хөх хошууны цахар аялганы дуудлагыг стандарт аялганы үндэс суурь болгооор тогтсон юм.

“Нэмж засварласан хэвлэл”-д, үндсэн толгой үг 26 мянга орчим орсон бөгөөд бүгдэд нь олон улсын авианы тэмдэглээгээр “стандарт дуудлага”-ыг оруулж өгсөн нь урьд өмнө огт байгаагүй шинэлэг зүйл болсон юм. Энэ ч утгаараа, энэхүү “Монгол-Хятад толь” номон дахь монгол хэл нь БНХАУ дахь монгол үндэстнүүдийн бичгийн болон ярианы хэлний жишиг стандарт болно гэж үздэг юм.

## 1-2. Товчилсон үгийн таних тэмдэг

Нэг. Үгийн аймгийн товчилсон тэмдэг

[名] Жинхэнэ нэр	[形] Тэмдэг нэр	[代] Төлөөний үг
[数] Тооны нэр	[量] Тооллого үг	[时位] Орон цагийн нэр
[及] Идэвхтэй үйл үг	[不及] Идэвхгүй үйл үг	[代动] Төлөөний үйл үг
[助动] Туслах үйл үг	[联动] Дутмаг үйл үг	[副] Дайвар үг
[后] Дагавар үг	[连] Холбоос үг	[语] Сул үг
[情] Баймж үг	[感] Аялга үг	[拟] Авиа дуурайх үг

Хоёр. Найруулгын төрлийн товчилсон тэмдэг

〈口〉 Ярианы хэл	〈方〉 Нутгын аялгуу	〈书〉 Бичгийн хэл
〈旧〉 Хуучин үг	〈转〉 Утга шилжсэн	〈惯〉 Өвөрмөц хэллэг
〈委〉 Эерүүлэх үг	〈诙〉 Шог ярианы үг	〈讽〉 Марзан үг хэллэг
〈咒〉 Хараах үг	〈回〉 Цээрлэх үг	〈废〉 Хэрэглээнээс гарсан үг
〈尊〉 Хүндэтгэлийн үг		

Гурав. Судалгааны салбарын нэрний товчилсон тэмдэг

〈政〉 Улс төр	〈哲〉 Философи	〈经〉 Санхүү, эдийн засаг
-------------	--------------	-------------------------

〈军〉 Цэрэг, зэвсэгт хүч	〈农〉 Газар атриалан	〈牧〉 Мал аж ахуй
〈林〉 Ойн аж ахуй	〈工〉 Инженерийн технологи	〈商〉 Арилжа
〈教〉 Боловсрол	〈文〉 Уран зохиол	〈艺〉 Урлаг
〈史〉 Түүх	〈地〉 Геологи, газарзүй	〈语〉 Хэл, бичиг
〈体〉 Биеин тамир	〈逻〉 Логик	〈法〉 Хууль
〈宗〉 Шашин	〈物〉 Физик	〈化〉 Хими
〈数〉 Математик	〈生〉 Биологи	〈动〉 Зоологи
〈植〉 Ботаник	〈生理〉 Физиологи, анатоми	〈医〉 Эрүүл мэнд, эрүүл ахуй
〈气〉 цаг агаар	〈天〉 Астрономи	〈计〉 Компьютер
〈考〉 Архиологи	〈音〉 Дуу хөгжим	

## Нэмэлт 2. Компьютерын гарны товчууд ба монгол үсэг, латин галигийн хамаарлын жишээнүүд

Компьютерын гарны товчууд болон хайлтын цонхонд бичигдэх монгол бичиг, латин галигийн хамаарлыг жишээгээр харуулж тайлбарлай. Хайлтын хамрах хүрээг “Монгол бичиг” болговол монгол бичгээр, харин “Латин галиг” болговол латин галигаар гарч ирнэ.

【Дасгал 1】 Компьютерын гарнаас дараах байдлаар оруулаад үр дүнг нягталж харна уу.

Компьютерын гар	Хайлтын цонхонд гарах үг		Кирилл үсгээр
Оруулах үг	Монгол бичиг	Латин галиг	
nige	нэг	nige	Нэг
qoyag	хоёр	χoyer	Хоёр
Gurba	гурав	γurba	Гурав
dOrbe	дөрөв	dörbe	Дөрөв
tabu	тав	tabu	Тав
jirGuG_a	зургаа	žirγuγ_a	Зургаа
doloG_a	долоо	doloy_a	Долоо
nai`ma	найм	naima	Найм
yisU	ёс	yisü	Ёс
arba	ар ав	arba	Арав

Монгол бичгээр үг оруулахдаа дараах байдлаар оруулж болно:

- “найм” (“Найм”) гэдэг үг нь нэлээд өвөрмөц байдлаар бичигддэг учир nai`ma гэж оруулна. Хэрэв naima гэж оруулахад хайлтын цонхонд “найм” гэж гарах боловч хайлтын үр дүнгээр “найм” гэсэн үг гарна.
- q болон k үсгийн оронд h гэж, мөн G-гийн оронд g үсэг хэрэглэж болно.
- Доогуур зураас буюу “\_” тэмдгийг товчилж бас болдог. Доогуур зураасыг товчилсон тохиолдолд “найм”, “хоёр” нь “найм”, “хоёр” гэсэн байдлаар харагдах ба хайлтанд ямар нэгэн саад учруулахгүй.

【Дасгал 2】 Хос эгшиг гэж нэрлэгддэг 2 эгшгээс бүтсэн авианы хувьд ai, ei, oi, ui, Uɪ гэж

бичиж оруулна.

Компьютерын гар	Хайлтын цонхонд гарах үг		Кирилл үсгээр
Оруулах үг	Монгол бичиг	Латин галиг	
ail	айл	ail	Айл
naija	наиҷа	naija	Найз
eimU	айм	eimü	Иим
neigem	нейгэм	neigem	Нийгэм
oir_a	ойр_а	oir_a	Ойр
qoin_a	хойно_а	χoin_a	Хойно
uitan	уйтан	uitan	Уйтан

- Доогуур зураас буюу “\_” тэмдгийг товчилж бас болдог. Доогуур зураасыг товчилсон тохиолдолд өөрчлөх нь өөрчлөх нь гэсэн байдлаар харагдах ба хайлтанд ямар нэгэн саад учруулахгүй.

【Дасгал 3】 Угийн 2-р үеэс хойш орсон уруулын эгшгийн төрлүүдийг нь “Монгол-Хятад толь” номны бичилтийн дагуу хийсэн болно.

Компьютерын гар	Хайлтын цонхонд гарах үг		Кирилл үсгээр
Оруулах үг	Монгол бичиг	Латин галиг	
oimoso	өймсө	oimoso	Оймс
toGoso	тоос	toysoso	Тоос
siroi	широо	siroi	Шороо
qodoGodo	ходоод	χodoγodo	Ходоод
OndOr	өндөр	öndör	Өндөр
tOmOsO	төмөсө	tömösö	Төмс
irOgel	ирөөл	irögel	Ерөөл

【Дасгал 4】 Монгол бичгээр үг оруулах жишээний үргэлжлэл:

Компьютерын гар	Хайлтын цонхонд гарах үг		Кирилл үсгээр
Оруулах үг	Монгол бичиг	Латин галиг	
quluGan_a	жүлүүгэн	quluGan_a	Хулгана
Uker	үхэр	üxer	Үхэр
bars	барс	bars	Барс
taulai	таулай	taulai	Туулай
luu	луу	luu	Луу
moGai	могай	moγai	Могой
mori	морь	mori	Морь
qoni	хонь	χoni	Хонь
becin	бич	bečin	Бич
takiy_a	таксиа	taxiy_a	Таксиа
noqai	нохой	noχai	Нохой
Gaqai	гахай	γaχai	Гахай

【Дасгал 5】 Монгол бичгээр үг оруулах жишээний үргэлжлэл:

Компьютерын гар	Хайлтын цонхонд гарах үг		Кирилл үсгээр
Оруулах үг	Монгол бичиг	Латин галиг	
kOke	хөх	xöxe	Хөх
ciki	чих	čixi	Чих
jirUke	Зүрх	žirüxe	Зүрх
sir_a	Шар	sir_a	Шар
Suugiyان	Шуугиан	šuugiyān	Шуугиан
SugUr	Шүүр	šügür	Шүүр
mingG_a	Мянга	mingγ_a	Мянга
mOnggO	Мөнгө	mönggö	Мөнгө
sedkil	Сэтгэл	sedxil	Сэтгэл
qubisqal	Хувьсгал	χubisχal	Хувьсгал

### Нэмэлт 3. Монгол бичгээр хайлт хийхдээ анхаарах зүйлс

Монгол бичигт ижил бичлэгтэй боловч өөр дуудлагатай “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд хэд хэд байдаг бөгөөд энэ нь монгол бичгээр хийх хайлтандаа ихээхэн нөлөөлдөг билээ.

Жишээлбэл: *t* үсэг болон *d* үсгүүд нь үндсэндээ адил хэлбэр лүрстэй үсгээр бичигдэх бөгөөд, гарнаас *tolı* гэж оруулсан ч, *doli* гэж оруулсан ч, хайлтын цонхон дээр *ж* гэсэн ижил бичилтээр гардаг.

Гэхдээ, *t* болон *d* нь өөр үсгүүд учир *tolı* гэж оруулах тохиолдол болон *doli* гэж оруулах тохиолдолд хайлтын үр дүн нь өөр өөр гарна.

• *toli* (ᡨᠣᠯᡳ) гэж хайлт оруулахад (эхний хэсэг нь таарсан)

蒙文词条		转写字母	国际音标	词类/中文译文	
ᡨᠣᠯᡳ(ᡩ)	toli(n) /1	töl	(名) ①镜子 ②型镜 ③〈转〉鉴, 般鉴, 借鉴: <i>ᡨᠣᠯᡳ</i> 借鉴 ④〈旧〉护心镜 ⑤指甲根。	1072a	
ᡨᠣᠯᡳ	toli /2	töl	(名) 字典, 词典: <i>ᡨᠣᠯᡳ</i> <i>ᡨᠣᠯᡳ</i> 解释词典; <i>ᡨᠣᠯᡳ</i> 百科词典。	1072a	
ᡨᠣᠯᡳ ᠠጀᠥ	toli üges		收进词典的词语。	1072a	
ᡨᠣᠯᡳ እጀᠥ ᠠጀᠥ	toli nairayulxu ary_a		辞书编纂法。	1072a	
ᡨᠣᠯᡳ/ᡨ ນາᡨ	tolin-u xairčay		镜匣。	1072a	
ᡨᠣᠯᡳ/ᡨ ᠰර	tolin-u ger		镜袋。	1072a	

• *doli* (ᡨᠣᠯᡮ) гэж хайлт оруулахад (эхний хэсэг нь таарсан)

蒙文词条		转写字母	国际音标	词类/中文译文	
ᡨᠣᠯᡮ	doliixu	dəlɪɪxu	(不及) ①斜视 ② → <i>ᡨᠣᠯᡮ</i> ① (204)	1188b	
ᡨᠣᠯᡮ	doliu	dəlɪu	(形) ① → <i>ᡨᠣᠯᡮ</i> (下段:1188c) ②斜的, 歪斜的: <i>ᡨᠣᠯᡮ</i> <i>ᡨ</i> 歪斜的犄角。	1188b	
ᡨᠣᠯᡮᡜ	doliudaxu	dəlɪɪdədəx	(不及) → <i>ᡨᠣᠯᡮᡜ</i> (下段:1188c)	1188b	
ᡨᠣᠯᡮᡧ	dolingyar	dəlɪɪŋjər	(形) 老成的, 老练的, 富有经验的: <i>ᡨᠣᠯᡮᡧ</i> <i>ᡨ</i> 老练的人。	1188b	
ᡨᠣᠯᡮᡨ	dolingyar laxu	dəlɪɪŋjərləxu	(不及) 表现老练, 显示老成。	1188c	

Дээрх хоёр жишээнээс харвал хайлтын цонхонд *doli* гэсэн адилхан бичилтээр харагдах боловч хайлтын үр дүн нь огт өөр болж байна. Зөвхөн үсгийн хэлбэр дүрсийг (*doli*) харснаар тухайн үг *toli* болон *doli*-ын аль нь болохыг ялган таних боломжгүй гэдэг нь монгол бичгийн өвөрмөц онцлогийн нэг билээ.

Түүнчлэн, монгол бичгийн эгшиг болох *o* (4-р эгшиг) ба *u* (5-р эгшиг) ч мөн адил яг ижилхэн бичигддэг “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд юм. Тиймээс зөвхөн *toli* ба *doli* төдийгүй, *tuli* болон *duli* ч мөн адил *doli* гэсэн яг адилхан бичилтээр бичигддэг. Харахад яг ижилхэн (*doli*) мэт боловч, *t*, *d*, *o*, *u* гэж дуудагдах өөр өөр үсгүүд учир тус бүрээр нь хайлтын үр дүн нь өөр өөрөөр гарч ирдэг.

- *tuli* (ᡨᠯᡳ) гэж хайлт оруулахад (эхний хэсэг нь таарсан)

<input checked="" type="radio"/> 蒙文词条 <input type="radio"/> 转写字母 <input type="radio"/> 全文	<input checked="" type="radio"/> 前段一致 <input type="radio"/> 完全一致 <input type="radio"/> 后段一致 <input type="radio"/> 部分一致	<input type="checkbox"/> 模糊查询 <input type="checkbox"/> 不分大小写 <input type="checkbox"/> 不包括副条	蒙汉词典 ▾ 30行 ▾
ᡨᠯᡳ	<input type="button" value=""/> <input type="button" value=""/> 1次 <input type="button" value=""/> <input checked="" type="checkbox"/> 蒙汉词典		
蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
ᡨᠯᡳ	tuliχu	tulix	(不及)(工作)吃力、费劲。
			1087a

- *duli* (ᡨᠯᡳ) гэж хайлт оруулахад (эхний хэсэг нь таарсан)

<input checked="" type="radio"/> 蒙文词条 <input type="radio"/> 转写字母 <input type="radio"/> 全文	<input checked="" type="radio"/> 前段一致 <input type="radio"/> 完全一致 <input type="radio"/> 后段一致 <input type="radio"/> 部分一致	<input type="checkbox"/> 模糊查询 <input type="checkbox"/> 不分大小写 <input type="checkbox"/> 不包括副条	蒙汉词典 ▾ 30行 ▾
ᡨᠯᡳ	<input type="button" value=""/> <input type="button" value=""/> 13次 <input type="button" value=""/> <input checked="" type="checkbox"/> 蒙汉词典		
蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文
ᡨᠯᡳ	duli	dulɪ	(形) ①不足的，欠缺的，差些的 ②中常的，适中的 (副)稍，稍微: <i>ᡨᠯᡳ</i> <i>ᡨᠯᡳ</i> 少微小一点。
ᡨᠯᡳ <i>ᡥᡳ</i>	duli xög		①正好，恰好 ②正是时候。
ᡨᠯᡳᠶᠠᠨ	duliχan	dulɪχən	(形) 不足的，欠缺的。
ᡨᠯᡳ៥	duliχu	dulix	(不及)不足，欠缺。
ᡨᠯᡳᠮ	dulim	dulim	(形) ① = <i>ᡨᠯᡳ</i> (中段:1202b) ② → <i>ᡨᠯᡳᠶᠠᠨ</i> <i>ᡨᠯᡳ</i> (1204)
ᡨᠯᡳᠮᠠᠭ	dulimay	dulɪmɑg	(形) ①不足的，欠缺的，略差的 ② → <i>ᡨᠯᡳᠶᠠᠨ</i> <i>ᡨᠯᡳᠮ</i> (1204)

Монгол бичигт үүнээс гадна *g*, *k* гийгүүлэгчүүд болон *O* (6-р эгшиг), *U* (7-р эгшиг) зэрэг эгшгүүд ч мөн адил “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд юм. Мөн, *a*, *e* эгшгүүд ч бас үгийн эхэнд орсноос бусад үедээ ижил бичигддэг тул монгол бичиг нь зөвхөн хэлбэр дүрсийг нь хараад яг аль үсэг (аль дуудлага) нь болохыг нь мэдэх боломжгүй байх тохиолдол олон байдаг билээ.

Ийм учраас, Монгол бичгээр хайлт хийхэд хайх гэж буй үгээ зөв бичсэн хэрнээ хайлт зөв явагдахгүй тохиолдол цөөнгүй гардаг юм.

Тухайлбал, дараах жишээн дээр хайлтын цонхонд *ነግ* (*nige* “нэг”) гэсэн үгийг зөв оруулсан мэт боловч хайлтын дүн нь “Not Found!” гэж гарсан байна.

<input checked="" type="radio"/> 蒙文词条 <input type="radio"/> 转写字母 <input type="radio"/> 全文	<input checked="" type="radio"/> 前段一致 <input type="radio"/> 完全一致 <input type="radio"/> 后段一致 <input type="radio"/> 部分一致	<input type="checkbox"/> 模糊查询 <input type="checkbox"/> 不分大小写 <input type="checkbox"/> 不包括副条	蒙汉词典 ▾ 30行 ▾
ነግ	<input type="button" value=""/> <input type="button" value=""/> <input type="button" value=""/> <input checked="" type="checkbox"/> 蒙汉词典		
Not Found!			

Энэ нь уг толинд *ነግ* (*nige* “нэг”) гэсэн үг байхгүй гэсэн үг биш, харин *nike* гэж бичиж хайсан учраас ийм үр дүн гарсан байна.

- Харин *nige* (нэг) гэж зөв оруулж хайвал дараах үр дүн гарна.

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文	
нэг(√)	nige(n)	nəg	(数) ①一 ②一个(件、只……) ③一次(回、下……) ④一岁 ⑤同，同一个，同样的： нэг/ нэг өөрөдөл 我们是一家人； нэг төлөөлж/ нэгдэж 同乡人 ⑥一(表示整个、全部等)： нэг өдөр 一屋子人 ⑦(有时只用作逻辑重音的标志，没有具体意义)： эх/ нэг өдөрөөс/ эхийг нэгийн өдөр 还需要三十来车土； нэг тол/ нэгдэж 许多人； нэг төр/ нэгдэж 好好地想一想吧； нэг нэгдэж ясныг 我来说一说 ◇ нэг нэгдэж 一丘之貉； нэгийн талын/ нэгийн ажлын/ нэгийн өндөртэй 決一雌雄； нэг төлөхийн нэг талын/ нэгийн 吃一堑长一智。	370b
нэг тааныг	nige aimay		同类，同种。	370b
нэг нэр өр	nige ami-bar		一口气地，拼命地。	370b

Доорх жишээ ч гэсэн дээрхтэй адил бөгөөд, хайлтын цонхонд *qoyar* (*qoyar* “хоёр”) гэж бичсэн мэт боловч, хэрэг дээрээ оруулсан үг нь *quyar* учир хайлтын үр дүн нь “Not Found!” болсон байна.

● 蒙文词条 ○ 转写字母  
○ 全文
● 前段一致 ○ 完全一致 ○ 后段一致  
○ 部分一致
□ 模糊查询 □ 不分大小写  
□ 不包括副条
蒙汉词典 ▾  
30行 ▾

▼ 𠂊
🔍
↶ ↷
蒙汉词典

Not Found!

- Харин хайлтын цонхонд *qoyar* (*qoyar*) гэж зөв бичиж хайлт хийвэл дараах үр дүн гарах юм:

蒙文词条	转写字母	国际音标	词类/中文译文	
нэгийн	xoyar	χɔjɪr	(数) ①二，两 ②两个(只、件……)： нэгийн та/ нэгийн 二者择一 ③两次(回、下……) ④两岁 ⑤(出现于并列的两个词之后，有时可译成汉语连词《和》)： нэгийн та/ нэгийн 父亲和母亲 ◇ нэгийн өснөхийн та/ нэгийн 脚踏两只船(直译：骑两个头的马)。	661b
нэгийн өснөхийн та/ нэгийн	xoyar egeljitu suryayuli		二部制学校。	661b
нэгийн өснөхийн та/ нэгийн	xoyar esitü onol		(哲) 二元论。	661b

Дээрх жишээнүүдэд дурдсанчлан, хайлтын цонхонд монгол бичгийн бичилтээр алдаагүй зөв бичсэн ч оруулсан үсэг нь таараагүй бол хайлт үнэн зөв хийгдэж чаддаггүй. Монгол бичгээр хийх хайлтын үед, хайх гэж буй үгэнд “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд орсон байвал хэлбэр дүрс нь хэдий адилхан ч гэсэн үсэг нь өөр өөр учир хайлтын үр дүн өөр гардаг гэдгийг үргэлж анхаарч байх шаардлагатай .

Мөн түүнчлэн, “Бичлэг ижил, дуудлага өөр” үсгүүд бүхий үгийг хайх хайлтаа хялбар дөхөм болгохын тулд хайлтын нэмэлт сонголт болгон “Тодорхой бус хайлт” гэсэн хайлтыг оруулж өгсөн билээ.

⇒ 3-3-3-1. Тодорхой бус хайлт ■Тодорхой бус хайлтын хэрэглээ